

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023

Бидний зорилт: **БҮРТГЭЛИЙН** цахим үйлчилгээг
БҮХ НИЙТИЙН
хэрэглээ



Дорнод аймаг, Хэрлэн сум,
6-р баг ЗДТГ-ын нэг давхар



www.dornod.burtgel.gov.mn



98-970-970



dornod@yahoo.com



АГУУЛГА

1. Хүний нөөц
2. Шинэ санаа, бүтээлч ажил
3. Ил тод нээлттэй байдал
4. Бүртгэлийн тоон үзүүлэлт
5. Эрүүл мэнд
6. Сургалт
7. Хамтын ажиллагаа
8. Санхүү үйлчилгээ
9. Өргөдөл гомдол
10. Бусад



ХҮНИЙ НӨӨЦ 1

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахаар Сити Их сургуулийн эрх зүйн бакалаврын эчнээ ангид 2 албан хаагч, Глобал Удирдагч Их сургуульд эрхзүйн бакалаврын эчнээ ангид 3 албан хаагч, Орхон Их сургуулийн эрх зүйн эчнээ ангид 2 нийт 7 албан хаагч суралцаж байна.

2023 онд 2 албан хаагч шинээр томилогдож, 2 албан хаагч ажлаас чөлөөлөгдөж, 2 албан хаагч сэлгэн ажиллаж, 1 албан хаагч хүүхэд асрах чөлөө авсан.

Төрийн албан хаагчийн дэлгэрэнгүй, Төрийн албанд ажилласан жилийн, зэрэг дэвийн, нас, хүйс, боловсрол, мэргэжил гэх мэт суурь 3 судалгааг шинэчлэн гаргаж УБЕГ-т хүргүүлсэн.

Сул орон тооны 4 мэдээллийг байгууллагын www.dornod.burtgel.gov.mn цахим хаягт байршуулж ажиллав.


УБЕГ-ын "Хүндэт жуух бичиг"-ээр 2 албан хаагчийг шагнуулахаар саналыг хүргүүлсэн.

УБЕГ-ын даргын 2023 оны Б/79 дүгээр тушаалаар төрийн захиргааны 14 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон ахиулсан.

Хэлтсийн даргын 2023 оны Б/13 дугаар тушаалаар 2 албан хаагчийн гэр бүлд шинээр хүүхэд төрсөн тул тус бүр 100,000 төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон.

"Албан хаагч бүрт - орон сууц" хөтөлбөрийн хүрээнд хөнгөлттэй орон сууцанд хамрагдах хүсэлтэй албан хаагчдын судалгааг УБЕГ-т хүргүүлсэн.

Нийт 31 албан хаагч



Бакалавр
24

Төрийн захиргааны 23 албан хаагчаас



Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 10.2-т заасны дагуу албан хаагчдын цаг ашиглалтыг хянах зорилгоор зөвшөөрөл авсны үндсэн дээр нүүр таних программ ашиглаж байна.



Албан хаагчдын эрүүл мэнд, бие бялдрыг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ХХО-ны спорт заалтай гэрээ байгуулан ажиллаж байна.



ТАНД ТУСЛАХ ЦАХИМ ХӨТӨЧ

www.e-mongolia.mn
www.burtgel.gov.mn
<http://dornod.burtgel.gov.mn>



ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН 3 ДУГААР САРД
ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

БҮТЭЭМЖИЙГ ДЭМЖСЭН
НОГООН БАЙГУУЛЛАГА

【 2 】 ШИНЭ САНАА, БҮТЭЭЛЧ АЖИЛ

"ЦАХИМ ХӨТӨЧ БУЛАН"-г шинэчлэлээ.

Хэрлэн сумын ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр Улсын бүртгэлийн нэгж Хэрлэн сумын "НЭГ ЦОНХ"-ны үйлчилгээнд "ЦАХИМ ХӨТӨЧ БУЛАН"-г нээн ажиллуулж байна.

Энэхүү "ГЭРЭГЭ КИОСК" машинаас иргэд Улсын бүртгэлийн үйлчилгээний болон бусад төрлийн төлбөр хураамжийг тушаах боломжтой.

Мөн "УХААЛАГ ДЭЛГЭЦ"-ийг ашиглан E-Mongolia цахим системээс бүх төрлийн лавлагаа, үйлчилгээ авах боломж бүрдэж байна.

"МОНГОЛ ШУУДАН" ХК-тай хамтран ажиллах гэрээ байгууллаа.

"Монгол шуудан" ХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж гадаад паспорт, цахим иргэний үнэмлэх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, лавлагааг түргэн шуурхай, найдвартай гараас гарт хүргүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

"НИЙГМИЙН ЦОГЦ ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ"-г үзүүлж ажиллалаа

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар алслагдсан Халхгол, Цагаан-Овоо, Баян-Уул сумын 200 иргэнээс гадаад паспорт захиалга авч 157 эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

"СУМДЫН ЗДТГ"-тай хамтран ажиллалаа

Мэнэнгийн отряд, Дашбалбар, Баяндун, Хөлөнбуйр сумын ЗДТГ-тай хамтран ажиллаж 297 иргэнээс гадаад паспортын захиалга авч, 142 иргэнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг олгож ажилласан.

"ВИДЕО МЭДЭЭ"-г цахимд байршуулж эхэллээ.

Улсын бүртгэлийн байгууллагад хийж хэрэгжүүлж буй онцлох ажлуудыг иргэдэд сурталчилах, таниулах зорилгоор видео мэдээг байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд сар бүр байршуулан ажиллаж байна.



ШИНЭ САНАА, БҮТЭЭЛЧ АЖИЛ


Улсын бүртгэлийн үйлчилгээг сурталчилах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг баннер, видео хэлбэрээр хийж байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулж ажиллалаа. Үүнд:

- Цахим гадаад паспорттой холбоотой түгээмэл асуулт хариулт /видео/
- Цахим гадаад паспортын тухай /видео/
- Үндэсний энгийн болон үндэсний энгийн цахим гадаад паспортын төлбөрийн мэдээлэл
- Тоон гарын үсгийн гарын авлага
- Тоон гарын үсгийн ач холбогдол /видео/
- Тоон гарын үсгийн баннер
- Иргэний улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн хугацаа

АЛБАН ХААГЧДЫН АЖЛЫН БАЙРНЫ ОРЧИН НӨХЦЛИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН АСУУЛГА

Уг судалгааны зорилго нь байгууллагын соёл, ажлын орчин, ажилтанд үзүүлж байгаа нийгмийн баталгаа, сургалт, дэмжлэг, хамт олон хоорондын харилцаа, хандлага, уур амьсгал, үйл ажиллагаанд ханамж хэр байгаа талаар тодорхойлж, үнэлэлт, дүгнэлт хийж, илэрсэн алдаа дутагдлыг арилгах, цаашид сайжруулах зорилготой.

Судалгаанд 21 албан хаагч хамрагдсан судалгааны агуулгаас авч үзвэл сумдын улсын бүртгэгч нарын ажлын байрны орчин нөхцөл дунд зэрэг, тав тух муутай, албан хаагчдын хоорондын харилцаа сэтгэл ханамж сайн, нийгмийн халамж дунд зэрэг байгаа нь судалгаанаас харагдаж байна.



Цахим гадаад паспорттой холбоотой түгээмэл асуултууг

ҮНДЭСНИЙ ЭНГИЙН БОЛОН ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ЦАХИМ ГАДААД ПАСПОРТЫН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ			
Эрх	Завсгалтын төрөл	Хугацаа	Үндэсний энгийн гадаад паспорт /хэлтээл/
1	Аж ууваг болон хуудас, үндэсний зургийн төлбөрдөг	40 000 төг	Үндэсний энгийн Цахим гадаад паспорт /хэлтээл/
			60 000 төг
			Үндэсний энгийн Цахим гадаад паспорт /хэлтээл/
			11000 төг
			Үндэсний энгийн Цахим гадаад паспорт /хэлтээл/
			3000 төг

Бүртгэлийн хэлтэс

1. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

2. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

3. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

4. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

5. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

6. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

7. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

8. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

9. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

10. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

11. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

12. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

13. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

14. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

15. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

16. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

17. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

18. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

19. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

20. Хүмүүн: иргэдийн гэгдэл, иргэдийн үйлчилгээний төв

Иргэн цахим "Тоон гарын үсгийн бүртгэлд идэвхтэй хамрагдахыг Уриалж байна.

Улсын бүртгэлийн байгууллагаас 10 мянган хүртэлх иргэдэд цахим, үндэсний бүртгэлийн иргэн үйлчилгээний цахим үйлчилгээний системийг ашиглах боломжийг олгож байна. Үйлчилгээний цахим үйлчилгээний системийг ашиглахын тулд цахим гадаад паспорттой байрлуулах.

Таны бичиг үзүүр, хаяг, хэрэглэж байгаа хаяг

- Бүртгэлийн үйлчилгээний цахим үйлчилгээний системийг ашиглах
- Цахим гадаад паспорт
- Бүртгэлийн үйлчилгээний системийг ашиглах
- Цахим гадаад паспорт

ХААН БАНК

Дорнод аймгийн улсын бүртгэлийн хэлтэс

УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛАГА, ХААН БАНКАЙ ХАМТРАН "ТООН ГАРЫН ҮСГ"

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ХУУЛИЙН ХУГАЦАА

Бүртгэлийн | Улсын бүртгэлд бүртгүүлэх | Хуулийн заалт

ЦАХИМ ГАДААД ПАСПОРТ

Цахим гадаад паспорт нь

ТООН ГАРЫН ҮСЭГ



Улсын бүртгэлийн байгууллага Хаан банктай хамтран "Тоон гарын үсэг идэвхжүүлэх аян"-ыг зохион байгуулсан бөгөөд 4 дүгээр сарын тоон гарын үсэг олголтын ажлаараа бусад аймаг, дүүргийн хэлтсүүдээ "ТЭРГҮҮЛЭН" ажиллалаа.

Дорнод аймгийн 16 ба түүнээс дээш насны 29890 иргэнд буюу 54 хувьд тоон гарын олгоод байна.

ДОРНОД АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



УЛСЫН БҮРТЭЛИЙН БАЙГУУЛЛАГА ХААН
БАНКТАЙ ХАМТРАН ТООН ГАРЫН ҮСЭГ
ОЛГОЛТЫГ ИДЭВХЖҮҮЛЭХ АЯН ЗОХИОН
БАЙГУУЛЖ БАЙНА.

ИРГЭН ТА ИДЭВХТЭЙ ХАМРАГДАНА УУ.

Хамрах хүрээ: Монгол улсын 16 ба түүнээс
дээш насны иргэд
Үргэлжлэх хугацаа: 2023.04.03-2023.06.30




<https://dornod.burtgel.gov.mn/>

98-970-970



ИДЭВХЖҮҮЛЭХ АЯН





БҮРТГЭЛИЙН ЦА
У Л С Ы Н
НЭМЭГДҮҮЛЭХ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

НЭЭЛТТЭЙ УТАС
98-970-970

dornod@burtgel.gov.mn

**ТАНД ТУСЛАХ
ЦАХИМ ХӨТӨЧ**

www.e-mongolia.mn
www.burtgel.gov.mn
<http://dornod.burtgel.gov.mn>

3 ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Улсын бүртгэлийн ерөнхий газар болон хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг цаг тухай бүр www.dornod.burtgel.gov.mn, www.facebook.com/Ubh.domod цахим хуудаснаа нийтлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд бодлого шийдвэр, цахим үйлчилгээ, улсын бүртгэлийн хууль тогтоомжтой холбоотой /e-Mongolia-н үйлчилгээ, Тоон гарын үсэг, Цахим гадаад паспорт, Хуулийн этгээдийн цахим гэрчилгээ/ 56 баннер, шторк, цаг үе, үйл явдалтай холбоотой 241 мэдээллийг байгууллагын www.dornod.burtgel.gov.mn цахим сайт www.facebook.com/Ubh.dornod фэйсбүүк /8125 дагагчтай/ хуудсаар тогтмол сурталчилж цахим хуудасны сэтгэгдэл, захиагаар хандсан 53 иргэнд зохих мэдээлэл, зөвлөгөөг хүргэж ажилласан.

Мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс УБЕГ-ын www.burtgel.gov.mn, аймгийн Засаг даргын Тамгын газрын www.dornod.gov.mn хуудсанд тавигдсан мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд хуваалцаж, иргэдийг мэдээ мэдээллээр тогтмол ханган ажиллалаа.

Бүртгэлийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах зорилгоор цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан “Үндэсний энгийн цахим гадаад паспортын тухай”, “Тоон гарын үсэг”, “Байнга оршин суугаа хаягийн бүртгэл” зэрэг сэдвээр тус тус мэдээлэл бэлтгэн байгууллагын цахим хуудас www.dornod.burtgel.gov.mn сайт болон Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк хуудас, орон нутгийн телевизээр дамжуулан иргэдэд хүргэн ажилласан.

Аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудыг зөвлөгөө, мэдээ, мэдээллээр хангаж өгөх зорилгоор “ДОРНОД АЙМГИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА” цахим хуудсыг тогтмол ажиллуулан хэвшээд байна

Байгууллагын “НЭЭЛТТЭЙ УТАС 98-970-970” дугаараас иргэд бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн мэдээллийг авах боломжтой бөгөөд тайлант хугацаанд 352 иргэнд үйлчлүүлсэн.



3

ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, түргэн шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр үйлчилгээний төлбөр, хураамжийг боловсронгуй болгох, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зорилгоор ГЭРЭГЭ КИОСК байршуулсан бөгөөд тайлант хугацаанд 19845 иргэнд үйлчилж ажилласан.

Улсын бүртгэлийн үйлчилгээний гарын авлагыг шинэчлэн гаргаж байгууллагын www.dornod.burtgel.gov.mn цахим сайт болон Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк хуудсаар дамжуулан тогтмол сурталчлан ажиллалаа.

Байгууллагын ил тод нээлттэй байдлыг ханган ажиллах үүднээс байгууллагын ухаалаг самбарт мэдээллийг тогтмол болон байнга шинэчлэн байршуулан ажиллав.

Улсын бүртгэлийн байгууллагад хийж хэрэгжүүлж байгаа онцлох ажлуудыг иргэдэд сурталчилах, таниулах зорилгоор видео мэдээг байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд сар бүр байршуулан ажиллаж байна.

Баяндун, Дашбалбар, Хөлөнбуйр, Халхгол сумдын ЗДТГ-тай хамтран "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг 2023 оны 04, 05 дугаар саруудад зохион байгуулж ажилласан. Үүнд:

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, бусад хууль дүрэм журмын хүрээнд 250 иргэнд мэдээлэл, зөвлөгөөг өгч, гадаад паспортын 297 материал хүлээн авч, газар болон үл хөдлөх эд хөрөнгийн 142 гэрчилгээг бичиж олгосон.

Монголын хуульчдын холбооноос жил болгон зохион байгуулдаг "Хуульчийн ПроБоно өдөр-2023" өдөрлөгт оролцсон. Уг нээлттэй хаалганы өдөр 85 иргэнд тоон гарын үсэг олгож, 150 иргэн, аж ахуй нэгжид Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, цахим гадаад паспорт захиалах, иргэний улсын бүртгэлийн лавлагаа, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ, хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалт, цахим гэрчилгээ олголт, e-Mongolia үйлчилгээг сурталчилж ажилласан.



ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН 3 ДУГААР САРД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

БҮТЭЭМЖИЙГ ДЭМЖСЭН НОГООН БАЙГУУЛЛАГА

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХУУЛЬЧ ДЭМЖСЭН АЖЛАА

ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮЗҮҮЛЭХ ӨДӨР

"ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨР-2023"

ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ӨГӨХ ӨДӨРЛӨГ


ИТГЭЛТ 14 1075 ПУЛС ОУ С ГАРЫН 01 УИЙН Ө БИРЭВЭ 10 00 1100 НАГШИН ӨЛӨӨН




4.1 Бичиг хэргийн эргэлт



Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт:



Гадаад паспортын чиглэлээр:



Сумдад хяналт шалгалт хийсэн талаар:



4 БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

4.2 Бүртгэл хяналтын чиглэлээр

Хяналт шалгалтын ажлын 22 заалт бүхий төлөвлөгөөг гаргаж, хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу 2023 онд хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн зөрчил илрүүлэн арилгах, зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоох, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бүртгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгыг тавьж ажиллалаа. Үүнд:

Хяналт шалгалтын чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/34 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу 627 бүртгэлд хяналт тавьж ажилласан байна. Үүнд:



УБЕГ-ын Хяналт шалгалтын газраас 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 6/3684 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 14 сумын 516 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт шалгалтыг гүйцэтгэсэн.

Сумдад хяналт шалгалт хийсэн талаар:

Хэлтсийн даргын батлагдсан төлөвлөгөөний дагуу сумдын бүртгэлийн үйл ажиллагаанд түүвэрчилсэн шалгалтыг Булган, Баян-дун, Баянтүмэн, Сэргэлэн, Халжгол, Матад, Хэрлэн, Хөлөнбуйр, Чулуунхороот сумдын 171 бүртгэлийн бүртгэлийн бүрдүүлбэр нотлох баримтыг шалгахад зөрчил илрээгүй.

Зөрчлийн тухай хууль, лавлагаа, шилжилт хөдөлгөөн цаашид анхаарах асуудлуудын талаар улсын бүртгэгч нарт онлайнгаар 1 удаагийн сургалт зохион байгуулж 1 удаа заавар зөвлөмж хүргүүлэн ажилласан.

Хялбаршуулсан журмаар зөрчлийг шийдвэрлэсэн чиглэлээр:

Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 299 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж торгох шийтгэл оногдуулан 7,295,000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.



Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн сонгуулийн СНЖ-д бүртгэлтэй эсэхээ шалгах <http://www.burtgel.gov.mn> холбоосыг тогтмол сурталчилан ажиллаж байна.



2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр АНСДИТХ-ын нөхөн сонгуулийн СНЖ-ыг хэвлэж, 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарыг байлцуулан сонгогчдын нэрийн жагсаалтыг хуулийн хугацаанд нь хүлээлгэн өгч, илтгэх хуудсыг 2023 оны 05 дугаар 23-ны өдөр ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.



4 БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

АНСДИТХ-ийн нөхөн сонгуулийн хүрээнд:

Чойбалсан суманд орон нутгийн нөхөн сонгууль болохтой холбогдуулан сонгуулийн тов, нутаг дэвсгэрийг зарласан ИТХТ-ыг мэдээллийн санд 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдөр скайнардан, шивж оруулсан.

ИУБГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу 2023 оны 03 дүгээр сарын 24-ний өдөр Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолд заасан сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн сонгуулийн эрх бүхий иргэнийг СНЖ-д бүрэн бүртгэсэн эсэхийг нягтлан шалгаж, илтгэх хуудсыг ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

УБЕГ-ын даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/829 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, илтгэх хуудсыг ИУБГ-т 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Аймаг, нийслэл сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн болон дахин сонгуульд ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудын судалгааг ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

Аймаг, нийслэл сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны нөхөн болон дахин сонгуульд ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудад нууцтай харьцан ажиллах зөвшөөрлийг хэлтсийн 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 03/306 тоот албан бичгээр тагнуулын байгууллагад хүргүүлсэн. Тагнуулын байгууллагаас 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 35/138 тоот албан бичгээр нууцтай харьцан ажиллахыг зөвшөөрсөн зөвшөөрлийг үндэслэн итгэмжлэгдсэн ажилтнуудыг тушаалаар томилж, гэрээ байгуулан ажиллаж байна.

2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр ИУБГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу УДШ, ШШГЕГ, ХХЕГ, БХЯ, ЦЕГ, ГИХГ-аас сонгуулийн ерөнхий хороогоор дамжуулан ирүүлсэн иргэдийн мэдээллийг үндэслэн сонгогчийн нэрийн жагсаалтад төлөв оноосон мэдээллийг нягтлан шалгаж, илтгэх хуудсыг 2023 оны 05 дугаар 04-ний өдөр ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.

Цаг бүртгэлийн программ

2023 оны 05 дүгээр сарын 19-ний өдөр ИУБГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу нэмэгдэж орсон 9 хаягт хамаарах иргэдийн мэдээллийг нягтлан шалгаж, илтгэх хуудсыг 2023 оны 05 дугаар 22-ны өдөр ИУБГ-т цахимаар хүргүүлсэн.



БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

4

4.4 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн эрх түдгэлзүүлсэн тухай 20 албан бичгээр 28 үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлж, эрх сэргээх тухай 12 албан бичгээр ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн 15 үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг сэргээж ажилласан.


“Монголын ипотекийн корпораци”-ийн 2023 оны 23/12, 23/13, 23/09, 23/21, “Үнэт цаас санхүүжилтийн корпораци”-ийн 21/23 тоот албан бичгүүдээр “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багц”-ыг тусгай тэмдэглэл хийж бүртгүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч худалдах, худалдан авах гэрээнд /ипотекийн зээл/ тусгагдсан 5 банкны 265 ширхэг эд хөрөнгөнд тусгай тэмдэглэл хийж, мэдээллийн санд бүртгэж хариуг хүргүүлж ажиллав.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хууль хяналтын байгууллагад 35 албан бичгээр 60 иргэн, хуулийн этгээдийн лавлагаа хуулбарыг олгож ажилласан.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаалаар 6 газар, 10 үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг хаах бүртгэлийг мэдээллийн санд бүртгэж ажилласан. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн 8/7219 чиглэлийн дагуу хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр үрэгдүүлсэн 26 газар, 8 үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцож шинээр гэрчилгээг бичиж олгосон.

УБЕГазрын ЭХЭУБГазрын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 6/277 тоот, 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 5/1854 тоот, 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 5/4053 тоот дугаартай хугацаатай үүрэг даалгаврын дагуу 2377 хувийн хэргийн мэдээллийн санд тулган шалгаж, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар, өөрчлөлт оруулах хяналтын улсын байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн № 1500 дүгнэлтийг үндэслэн 2060 бүртгэлийн /Хэмжээ бичигдээгүй, хэмжээ зөрүүтэй, Хаасан хувийн хэргийн төлөв өөрчлөгдөөгүй, газрын зориулалт эзэмших, ашиглах гэж буруу орсон/ алдааг арилгаж EPRS системд засвар өөрчлөлт оруулж ажиллалаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 4003 бүртгэл бүртгэгдсэн. Үүнийг ангилвал:



Аймгийн Иргэдийн Төлөөгчдийн Хурлын 2021 оны 7/09 дүгээр тогтоолоор батлагдсан сумдын хүн амд үйлчлэх “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ” төсөл арга хэмжээний хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчид бүртгэлийн үйлчилгээг 5 сумын иргэдэд үзүүлж ажилласан.

Сумдад ажиллах хугацаандаа Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, бусад хууль дүрэм журмын хүрээнд 348 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч, газар болон үл хөдлөх эд хөрөнгийн 204 гэрчилгээг бичиж олгосон.





4 БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

4.5 Хуулийн этгээдийн улсын бүртгэл

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн актын хүрээнд дараах ажил үүргийг гүйцэтгэсэн болно. Үүнд:

- 114 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын оноосон нэрийг баталгаажуулж 1.140.0 мян.төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэв;

- 102 аж ахуйн нэгж, байгууллага шинээр үүсгэн байгуулагдан үйл ажиллагаа эрхлэн явуулах зөвшөөрөл авч, хуульд заасан хугацаанд холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн тул улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ гардуулав.

- 391 нэр төрлийн нэмэлт өөрчлөлтийг цахим мэдээллийн санд оруулж, шинэчилсэн болон үрэгдүүлсэн, гэмтээсэн / шилжиж ирсэн/ шалтгаанаар 39 аж ахуйн нэгж, байгууллагад дахин гэрчилгээг тус тус олгосон болно. Үүний дотор хувийн 1 аж ахуйн нэгж, байгууллага хэлбэрээ өөрчилж бүртгүүлэв.

- Хуулийн этгээдийн 5 салбарыг шинээр бүртгэж гэрчилгээ олгосон байна. Мөн гэмтсэн, ашиглалтын шаардлага хангахгүй шалтгаанаар 4 салбарт дахин гэрчилгээ олгож ажилласан. Дорнод аймагт бүртгэлтэй 12 салбарт нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

- 3 аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасч татан буулган, хувийн хэргийг архивлан хэлтсийн архивт шилжүүлэхэд бэлэн болгоод байна. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хэлбэр регистр, оноосон нэр өөрчилсөн, татан буугдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын 43 тамгыг хураан авсан байна.

- 157 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тамганы хяналтын дугаар олгох үйлчилгээ үзүүлсэн. Төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн 34 албан бичгийг хүлээн авч 7 албан бичигт хариу хүргүүлэн ажиллалаа.

- Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 6 лавлагаа гарган хүргүүлж ажилласан.

Давхардсан тоогоор 655 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зөвлөгөө өгч, мэдээ мэдээллээр ханган Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд “Монгол улсын тэмдэгтийн хураамжийн хууль”ийн дагуу 13.230.0 мян.төгрөгийн хураамжийг улсын болон орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлэв. Өнөөдрийн байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт 2916 аж ахуйн нэгж байгууллагын хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнийг хэлбэр тус бүрээр нь харуулвал. Үүнд:



Цаашид хийх ажил, санал, санаачилга, шинэчлэн гүйцэтгэх ажлууд:

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг компани, холбоо /төрийн бус байгууллага/, сан хэлбэрт шилжүүлэх талаар мэдээлэл хүргүүлж ажиллах;



БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ 【 4 】

4.6 Архив

Иргэний улсын бүртгэлийн тасгийн архив:

Иргэний улсын бүртгэлийн архивт 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 181572 хувийн хэрэг ХААТР маягтууд хадгалагдаж байна. Хяналтын улсын байцаагч болон улсын бүртгэгч нарт 92 ширхэг хувийн хэрэг татан өгч Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 297 иргэний хувийн хэрэг ХААТР маягтуудыг хувийн хэргийн хадгаламжийн санд байршуулан ажиллаж байна. Иргэний улсын бүртгэгч нараас 3232 ХААТР маягтуудыг хүлээн авч байршуулах ажлыг хийж байна. Хэрлэн суманд нэг хаягт 10 дээш иргэн амьдарч байгаатай холбогдуулан Хэрлэн сумын 2-р баг, 4-р баг, 6-р баг, 9-р багийн ажлын албаны багын ажилтантай хамтран онлайн санд 318 хаягын тулгалт хийв.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив:

Тайлант хугацаанд 44507 хувийн хэрэг хадгалагдаж байна. Эд хөрөнгийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны явцад бий болсон нэмэлт өөрчлөлтийн 3260 нотлох баримт, шинээр үүсгэсэн газар өмчлөх эрхийн анхны бүртгэл 330, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэл 221 хувийн хэрэг архивт хүлээн авч байршуулсан. Мөн бүртгэлийн үйл явцад шалгах шаардлагатай 56 хувийн хэргийг улсын ахлах бүртгэгч болон улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгсөн. Архивын мэдээ тайланг тухай бүрт нь гарган холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив:

Тус архивт 2916 хувийн хэрэг хадгалагдаж байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цаасан хувийн хэргийг цахим мэдээллийн сантай тулган шалгахтай холбогдуулан 30 ширхэг хувийн хэргийг улсын бүртгэгчид хүлээлгэн өгсөн. Шинээр үүссэн аж ахуй нэгжийн 104 хувийн хэрэг, нэмэлт өөрчлөлтийн давхардсан тоогоор 391 нотлох баримтыг хүлээн авсан. Архивын мэдээ тайланг тухай бүрт нь гарган холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

Бусад ажил: УБЕГ-ын УБНА-ын даргаас 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн ирсэн чиглэлийн дагуу 2022 онд хадгалах хугацаа нь дууссан архивын санд хадгалагдаж байгаа иргэний гэр бүлийн байдлын хадгаламжийн нэгж, иргэний улсын бүртгэлийн 60258 хуудас баримт бичиг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт хураагдсан тамга тэмдэгийг М.Галбадрах /ББНШК-ын ахлах/, С.Батчимэг /ББНШК-ын гишүүн/, Л.Туяажаргал нар 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Дорнод аймгийн “Нисэх онгоцны буудал”-ын уурын зууханд устгаж дууссан.






5 ЭРҮҮЛ МЭНД

Сар шинийн баярыг угтаж иргэдийг эрүүл, цэвэр орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүн амыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж, эрүүл ахуйг сайжруулах зорилгоор Хэрлэн сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/34 дүгээр захирамжаар “Цагаан сар – Цэвэр хот” аяныг зарласан. Тус хэлтийн албан хаагчид дээрх аяны хүрээнд 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр нийтийн эзэмшлийн 50м хүртэлх талбайн хогхаягдлыг цэвэрлэлээ.

Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж, эрүүл ахуйг сайжруулах, хүн амыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тус хэлтийн албан хаагчид 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хариуцсан талбай болох Хэрлэн голын ногоон бүсийн цэвэрлэв.

Аймгийн ЭМГазраас төрийн байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулсан “ЭНЭ ЖИЛДЭЭ ЭРҮҮЛ ЖИНДЭЭ” аяны хүрээнд иргэдийн илүүдэл жин таргалалт, эрүүл зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэх чиглэлээр танхимын сургалтад 15 албан хаагч хамрагдсан.

Эрүүл амьдралын хэв маягийг өдөр бүр хэвшүүлэх зорилгоор “Энэ жилдээ Эрүүл жиндээ” болзолт уралдааны хүрээнд зохион байгуулж буй дасгалын цагаар шугаман бүжиг, түмэн дасгалыг хамт олноороо хийж хөдөлгөөний хомсдолоос сэргийлэн идэвхжүүлэн хамт олноороо нэгдлээ.





6 СУРГАЛТ

Сургалтын ажлын хэсэг нь 2023 онд 18 нэр төрлийн сургалт зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгаснаас тайлант онд нийт 74 сургалт / бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 5 сургалт, албан хаагчдын хандлага хариуцлага, ёс зүйн чиглэлээр 3, бусад чиглэлээр 7, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан болон хамтарсан сургалт 59, давхардсан тоогоор 455 албан хаагч хамрагдаж, төрийн байгууллагын 10335 гаруй албан хаагчийг хамруулж ажиллалаа.

ᠮᠣᠩᠭᠣᠯᠠᠭᠤᠨ
ᠤᠯᠤᠰᠤᠨ
ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯᠢᠶᠢᠨ
ᠶᠡᠷᠦᠨᠬᠢᠭᠢᠷᠠᠭᠤᠨ
ᠭᠠᠷᠠᠭᠠᠨ



ᠮᠣᠩᠭᠣᠯᠠᠭᠤᠨ
ᠤᠯᠤᠰᠤᠨ
ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯᠢᠶᠢᠨ
ᠶᠡᠷᠦᠨᠬᠢᠭᠢᠷᠠᠭᠤᠨ
ᠭᠠᠷᠠᠭᠠᠨ

Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан 9 удаагийн онлайн сургалтад / бүртгэлийн чиглэлээр - 5, хяналт, шалгалтын чиглэлээр - 1, бусад - 3, давхардсан тоогоор нийт 270 албан хаагч танхимын 3 удаагийн сургалтад 3 албан хаагч бүрэн хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн. Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх “Тоон гарын үсгийн талаарх” сургалтыг 50 байгууллагын 10335 гаруй албан хаагчдад хүргэж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан.



【 7 】 ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хэлтсийн дарга Д.Оюунбаяр, улсын бүртгэгч Ч.Энхцэцэг нар Улсын бүртгэлийн ерөнхий газар, БНСУлсын шүүхийн зөвлөлийн хамтарсан төрийн албан хаагчдын сургалтад хамрагдлаа. Уг сургалтад хамрагдах зардлаас **5,966,000** төгрөгийг аймгийн засаг даргаар шийдвэрлүүлсэн.



Хэрлэн сумын ЗДТГ-тай хамтран ажиллаж цахим төлбөрийн хэрэгсэл болох киоск болон дижитал киоск / Ухаалаг дэлгэц/ машиныг нэмэгдүүлж, Хэрлэн сумын **"НЭГ ЦОНХНЫ"**-ны үйлчилгээнд **"ЦАХИМ ХӨТӨЧ БУЛАН"** нээн байршуулан ажиллаж байна. /**11.535.000** төгрөг шийдвэрлүүлсэн./



Дотоод хэргийн их сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Отгонтэнгэр их сургууль хамтран ажиллаж үйлдвэрлэлийн дадлагын удирдамжийн дагуу улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаа, хууль эрх зүйн талаар мэдлэг мэдээлэл олгож ажиллалаа.

Монгол улсын засгийн газраас зохион байгуулсан жижиг дунд үйлдвэрийг дэмжих нэг цэгийн үйлчилгээнд хуулийн этгээдийн улсын бүртгэгч 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдөр хүртэл ажиллав.

Дорнод аймгийн Хэрлэн сумын 6 дугаар багаас "Явуулын багийн ажлын алба" үйл ажиллагааг 2023 оны 06 дугаар сарын 05-12-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уг үйл ажиллагаанд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ болон зөвлөгөө мэдээллийг 216 иргэнд хүргэн хамтран ажиллалаа.



САНГИЙН ЗЭЭЛ?
Д хэрэгсэл хамр
2023.03.01-09-ний өдрийг дуустал
08:00-12:00 13:00-17:00 цагийн хооронд
Үйлчилгээ үзүүлэх агентлагууд:
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар,
- Нийгмийн даатгалын хэлтэс,
- Төлөвлөгөө хэлтэс,
- Улсын бүртгэлийн хэлтэс,
-Хөгжлийн шийдэл ТББ





Дорнод аймгийн
Улсын бүртгэлийн хэлтэс

7 ХАМТЫН АЖИЛЛАГАА



Төрийн албаны
ерөнхий шалгалт

2023 оны 03 дугаар сарын 16, 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрүүдэд “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу шалгалтад оролцогч иргэдийн бүртгэлийг хурууны хээгээр бүртгэж ажиллалаа.

Хамтын ажиллагаа

Мэнэнгийн отряд, Халхгол, Цагаан-Овоо, Баян-Уул, Дашбалбар, Баяндун, Хөлөнбуйр сумын ЗДТГ-тай хамтран дээрх сумдад ажиллаж 542 иргэнээс гадаад паспортын захиалга авч, 185 иргэнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг олгож нийт 637 иргэнд үйлчиллээ үзүүлж 45,750,000 төгрөг хэмнэлээ.



Иргэний улсын бүртгэл

- Гадаад паспорт захиалах үйлчилгээ - 492
- Хил зорчих олон удаагийн үнэмлэх - 50
- Төрөөс хувьчилсан орон сууц, газар өмчлөх эрхийг анх удаа бүртгэх - 144



Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

- Барьцааны гэрээ дуусгавар болгох - 3
- Эд хөрөнгийн хаяг өөрчлөх - 4
- Худалдах, худалдан авах гэрээ - 7
- Өмчлөгч өөрт ногдох хэсгээ бэлэглэх - 9
- Бэлэглэлийн гэрээ - 8
- Барьцаалбартай барьцааны гэрээ - 1
- Лавлагаа - 9



Замын зардал



45,750,000 төгрөг





8

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тус хэлтэс нь 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын газарт хүргүүлэн санхүүгийн аудит хийлгэж, Төрийн аудитын газраас **“ӨӨРЧЛӨЛТГҮЙ”** дүгнэлттэй үнэлэгдсэн.

Тайланг хугацаанд 252,340,700 төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаа явуулж 245,020,207,18 төгрөгийн буюу 97% төсвийн гүйцэтгэлтэй, 7,320,492,82 төгрөгийн буюу 3%-ийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

Улсын төсөвт 76,643,413 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Батлагдсан төсвийн хүрээнд мөнгөн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулах, төсвийн зардлыг бууруулах ажлын хүрээнд орон нутгийн аж ахуй нэгжүүдээс үнийн судалгаа явуулж, бичгийн цаас нэг бүрийг 2300 төгрөгөөр хямд худалдан авч 103,545 төгрөгийн бодит хэмнэлттэй ажиллав.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг, үнэт цаас зарцуулалтын тайланг хуулийн хугацаанд УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэс болон төрийн санд хүргүүлсэн. 2023 онд бараа материал худалдан авахаар 10 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Бараа материалын худалдан авалтад 6,875,170 төгрөгийг зарцуулав.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж тайланг хугацаанд 69 мэдээлэлийг www.shilendans.gov.mn, байгууллагын www.ubh.dd.gov.mn сайтад 100% хуулийн хугацаанд үнэн зөв байршуулж ажилласан.

9

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ


Иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан нийт 17 санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэж хариу өгч ажилласан. Үүнийг ангилвал:

Хуулийн этгээдийн улсын бүртгэгчид 1 гомдол ирснийг шийдвэрлэн зохих хариуг өгч ажилласан.


Санхүүтэй холбоотой буцаалт хийх 16 өргөдлийг шийдвэрлэсэн.

Өргөдөл гомдлыг нээлттэй утас 98-970-970, өргөдөл гомдлын дэвтэр, санал хүсэлтийн хайрцаг, цахим хуудсаар хүлээн авч ажиллаж байна.

Төрийн аудитын газраас “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлттэй үнэлэгдсэн



Улсын төсөвт 76,643,413
төгрөгийн орлого төвлөрүүлсэн





[10] БУСАД



- Удирдлагуудын дунд зохион байгуулагдсан Олон төрөлт спортын тэмцээнд хэлтсийн дарга Д.Оюунбаяр амжилттай оролцож 2 дугаар байр эзэллээ.
- Байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор аймгийн Тагнуулын газартай хамтран 2023 оны 01 сард цас мөсний баяр зохион байгууллаа.
- Ахмадын баярын өдрийг тохиолдуулан хэлтсийн ахмад ажилтнуудад баярын мэндчилгээ, гарын бэлэг хүргүүлэв.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөн "Цаг гаргая" аянд нэгдлээ.
- Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд идэвхтэй хамрагдлаа.





10 БУСАД



АНХААРЧ ХАМГААЛЪЯ

Нэгдүгээрт хүүхэд үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй "АНХААРЧ ХАМГААЛЪЯ" 100 хоногийн аянд нэгдэв. Аяны хүрээнд хүүхдэд хүмүүжлийн эерэг хандлага төлөвшүүлэхээр байгууллагын гадна талбайд албан хаагчид хүүхдүүдийн хамт цэцгийн үрсэлгээг суулгав.



НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД



“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

МУ-н Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хаврын мод тарих аяны хүрээнд 2023.05.11-ний өдөр байгууллага хамт олноороо 110 мод тариалаа.





10 БУСАД




ОЛОН УЛСЫН ЭХ ҮРСИЙН БАЯР

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн "НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД" уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх зөвлөмжийн дагуу байгууллагын албан хаагчдынхаа хүүхдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй бэлгийн багцыг бэлтгэж хүүхэд бүрт хүргүүлэв.



Дорнод аймгийн
улсын бүртгэлийн хэлтэс

Аав ээжийн амин эрдэнэ
Азай буурцудын ар зээ
Ах эгийн хайртай дүү
Монголын минь ирээдүй болсон
Бацхан хоёрхон дүү нартаа
Цргэлж инээмсэглэн гэрэлтэх
Цээсгэлэнт сайхан ээжүүддээ
Эх үрсийн  баярын
мэнд  хүргэе 



Эх Үрсийн 
Баярын Мэнд!
06/01

Дорнод аймгийн нийт хүн амын 34.5 хувь
буюу 29134 нь 0-16 насны хүүхэд. Тэдний
14257 нь хүү, 14877 нь охин.
Аймгийн хэмжээнд 2023 онд
 319 эрэгтэй
 298 эмэгтэй шинээр мэндэлсэн байна.